

Эдийн засгийн бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах тухай

Эдийн засгийн бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах үйл явцыг [МУИС-ийн ректорын 2024 оны А/646 тоот тушаалын](#) хүрээнд явуулна. Шилжин суралцагч нь тус тушаалтай дэлгэрэнгүй танилцах үүрэгтэй.

Шилжилтийн бүртгэл

Шилжилтийн бүртгэлийг жилд хоёр удаа буюу

- Намрын улиралд 07 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 10-ныг дуустал
- Хавсрын улиралд 12 дугаар сарын 10-наас 01 дүгээр сарын 10-ныг дуустал

<https://burtgel.num.edu.mn> сайтаар зохион байгуулна.

Шилжин суралцахад тавигдах шаардлага

МУИС-ийн бакалаврын хөтөлбөр хооронд шилжин суралцахад

- Шилжих хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээлийг амжилттай судалсан байх
- Голч дүн 2.8 ба түүнээс дээш байх
- Суралцаж буй бүрэлдэхүүн/салбар сургуулийнхаа мэргэжлийн хөтөлбөрөөс сонгосон байх
- Эдийн засгийн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын зөрүүгүй, элссэн жилийнхээ МУИС-ийн босго оноог давсан байх (2024 оны Бакалаврын элсэлтийн журмын дагуу Математик (70%), Нийгмийн тухай мэдлэг эсвэл Англи хэл (30%), босго оноо 480)*
- Дүгнэгдээгүй “I”, “E”, “N/A” гэсэн үсгэн тэмдэглэгээгүй байх
- Сургалтын төлбөрийн өргүй байх

Дотоодын их, дээд сургуулиас шилжин суралцахад

- Шилжих хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээлийг амжилттай судалсан байх
- Төрийн өмчийн их, дээд сургуулиас шилжиж буй оюутны голч 3.0 ба түүнээс дээш, төрийн бус өмчийн их, дээд сургууль бол 3.5 ба түүнээс дээш байх
- Эдийн засгийн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын зөрүүгүй, элссэн жилийнхээ МУИС-ийн босго оноог давсан байх (2024 оны Бакалаврын элсэлтийн журмын дагуу Математик (70%), Нийгмийн тухай мэдлэг эсвэл Англи хэл (30%), босго оноо 480)*

Гадаадын их, дээд сургуулиас шилжин суралцахад

- МУИС-тай ижил болон дээгүүр эрэмбэтэй их, дээд сургуулиас шилжих бол голч дүн 2.5-аас дээш байх
- МУИС-иас доогуур эрэмбэтэй их, дээд сургуулиас шилжих бол голч дүн 3.2-оос дээш байх
- Гадаад улсын аль нэг дээд боловсролын сургалтын байгууллагаас МУИС-д ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах тохиолдолд элсэлтийн шалгалтын оноо шаардахгүй.

* Оюутны элссэн жилээс хамаарч Эдийн засгийн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын шаардлага, босго оноо өөр байж болзошгүй тул элссэн жилийнхээ Бакалаврын элсэлтийн журмыг хараарай.

Шилжилтийн шалгалт

Дээрх шаардлагуудыг хангаж <https://burtgel.num.edu.mn> сайтад шилжин суралцах хүсэлтээ өгсөн оюутнууд тус сайт дээр тавигдсан хуваарийн дагуу Микро эдийн засгийн үндэс (ECON101) болон Макро эдийн засгийн үндэс (ECON102) хичээлүүдийн агуулгаар бэлтгэсэн шилжилтийн шалгалт өгнө.

Шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтан, шилжин суралцах эрхээ авсан суралцагчдыг МУИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна.